**НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 15 өдөр　　　Дугаар А/82　　　Улаанбаатар хот

Шууд худалдан авах ажиллагааг зохион байгуулах Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтсийн өөрийн хөрөнгөөр санхүүжигдэх Олон нийтийн оролцоонд түшиглэсэн “Өдрийн үйлчилгээ” үзүүлэх болон “Гэрийн асрамжийн үйлчилгээ”-ний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах шууд худалдан авалтыг зохион байгуулах Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|---|---|---|
| Ажлын хэсгийн дарга: | Б.Мөнгөнтуяа | Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтсийн Хүний нөөц, дотоод ажил хариуцсан Ахлах мэргэжилтэн |
| Гишүүд: | Ө.Амарзаяа | Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан Ахлах мэргэжилтэн |
| | А.Наранцацрал | Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтсийн Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан Ахлах мэргэжилтэн |
| | Д.Даваасамбуу | 1 дүгээр хорооны иргэн |
| Нарийн бичиг | Э.Урансайхан | Худалдан авах ажиллагааны албаны Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн |

2.Хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахыг Ажлын хэсэг (Б.Мөнгөнтуяа)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа) -д даалгасугай

ЗАСАГ ДАРГА　　　　А.СҮХБОЛД

AJIL\2023 он ажил\захирамж

1123000150